



НИЙГМИЙН
ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР



ГЕРМАНЫ ОСЛЫН
ДААТГАЛЫН ГАЗАР



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
ХУДАЛДАА АЖ
ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

**“ОСЛЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦООНЫ
ХӨГЖИЛ:**

МОНГОЛ БА ГЕРМАН УЛСЫН ТУРШЛАГА”

ФОРУМЫН ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР ХОТ

2015.04.23

ЗӨВЛӨМЖ ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭР

БАЙГУУЛЛАГЫН НЭР

БАТАЛГААЖУУЛАЛТ

Нийгмийн даатгалын ерөнхий газар



Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим



Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо



Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци




Багануур сувилал



Эрдэнэт сувилал




Оюут сувилал



Орика Монголия ХХК



Оюутолгой ХХК




Германы ослын даатгалын газар



Швейцарийн хөгжлийн агентлаг

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг



ФОРУМЫН ЗӨВЛӨМЖИЙН ЗОРИЛТ

1. ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ЭРСДЛИЙГ ХУВААЛЦАХ, СЭРГЭЭН ЗАСАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗОРИЛГООР ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРТЭЙ УЯЛДУУЛАН ДЭД ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ;
2. ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТОГТООХ АРГАЧЛАЛ, ҮНДЭСЛЭЛИЙГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛЭХ;
3. ГАДААДЫН ИЖИЛ ЧИГ ҮҮЭРГТЭЙ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ҮР ДҮНТЭЙ ТУРШЛАГЫГ ӨӨРИЙН УЛСЫН ОНЦЛОГТ НИЙЦҮҮЛЭН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХАМТРАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ;
4. ОСОЛД ӨРТСӨН, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНӨӨР ӨВЧИЛСӨН ДААТГУУЛАГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРЫГ СЭРГЭЭН ЗАСАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ;
5. ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН, ПРОГРАМ ХАНГАМЖ БОЛОВСРУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙГ ОРОЛЦОГЧ ТАЛУУД ИЛ ТОД АШИГЛАХ БОЛОМЖ БҮРДҮҮЛЭХ;
6. ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛГООР ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙГ ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛТЭЙГЭЭР АЖИЛЛУУЛАХ;

ЗОРИЛТ I. ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ТОГТОЛЦООГ ШИНЭЧЛЭХ:

Даатгуулагчийг ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэл хуваалцах, сэргээн засах өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлыг зохион байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

- Ослоос урьдчилан сэргийлэх, бууруулах, судлах, хянах, эрсдлийг хуваалцах, сэргээн засах үйл ажиллагааны цогц даатгалын тогтолцоог хөгжүүлэх;
- Ослоос урьдчилан сэргийлэх, бууруулахад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны OHSAS 18001 стандартыг ажил олгогч байгууллагуудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Нийгмийн даатгалын урамшуулалын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгон эрсдлийн үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоонд шилжих арга замыг судлах, боловсруулах;
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагааг өргөжүүлж, осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, судалгаа хийх, сургалт, зөвлөгөө, баталгаажуулалт, хяналт, сэргээн засах үйлчилгээний зохицуулалтыг хариуцуулах;
- Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг үр дүнтэй зохион байгуулсан, эрсдлийг бууруулсан ажил олгогчийг нийгмийн даатгалын урамшууллын бодлогоор дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас эрсдэлд өртсөн даатгуулагчид учирсан хохирлыг буруутай талаар төлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс даатгалын сангаас зарцуулах урьдчилан сэргийлэх зардлыг бууруулах зорилгоор урьдчилан сэргийлэх зардлыг тухай бүрд нь нэмэгдүүлж ажиллах;

ЗОРИЛТ II. ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТОГТООЖ БУЙ БАЙДЛЫГ ӨӨРЧЛӨХ:

Ажил олгогчийн үйл ажиллагааны чиглэлийг харгалзан бүх ажилтанд ослын даатгалын шимтгэлийг ижил хэмжээгээр тогтоон тооцож байгааг өөрчлөх шаардлагатай гэж үзэн дараах шинэчлэлийн ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ.

- Үндэсний ажил мэргэжлийн жагсаалтад өөрийн орны онцлогийг тусгаж, олон улсын нэршилд нийцүүлэн, коджуулан шинэчлэх;
- Ажлын байрны нэршлийг нийгмийн даатгалын тайланд тусгах ажлыг эрчимжүүлэх;
- Үйлдвэрлэлийн Осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг ажлын байрны эрсдэлийг үнэлэх замаар шимтгэл төлөх журам, жагсаалтыг өөрчлөх /Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоол/;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон эрсдлийг үнэлэх чиглэлээр боловсон хүчнийг сургах мэргэшүүлэх;

ЗОРИЛТ III.ГАДААДЫН ИЖИЛ ТӨСТЭЙ БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ҮР ДҮНТЭЙ ТУРШЛАГЫГ ӨӨРИЙН УЛСЫН ОНЦЛОГТ НИЙЦҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ:

- Олон улсын байгууллага (Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Германы ослын даатгалын байгууллага болон бусад) -аас туршлага судлах, зөвлөх авч ажиллуулах, дэмжлэг туслалцаа авч хамтран ажиллах;

ЗОРИЛТ IV: ОСОЛД ӨРТСӨН ДААТГУУЛАГЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРЫГ СЭРГЭЭН ЗАСАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ;

Сэргээн засах тусламж, үйлчилгээний өнөөгийн байдал нь даатгуулагчийн хөдөлмөрийн чадварыг бүрэн сэргээх түвшинд хүрэхгүй байгааг харгалзан дараах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ.

- Сэргээн засах тусламж үйлчилгээний өнөөгийн байдалд иж бүрэн судалгаа, үнэлгээ хийх;
- Олон улсын байгууллагатай хамтран ослын даатгалын сангаас зохих хэсгийг санхүүжүүлэн сэргээн засах жишиг кабинетийг эмнэлэг, сувиллыг түшиглэн байгуулах;
- Сэргээн засах сувиллын тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, эмч мэргэжилтний чадавхийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийг дахин мэргэшүүлэх, давтан сургах, ажлын байранд эргэн орсон тохиолдолд урамшуулах тогтолцоог бий болгох;
- Хувь хүнд чиглэгдсэн сэргээн засах төлөвлөгөө гаргах ажлыг зохион байгуулах

ЗОРИЛТ V: ОСЛЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН БҮРДҮҮЛЭХ, АШИГЛАХ:

Мэдээллийн дутмаг байдал нь салангид тогтолцоотой холбоотой бөгөөд судалгаа тооцоолол хийх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого шийдвэр гаргахад шаардлага хангахгүйг дурдаад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

- Ослын нэгдсэн мэдээллийн сангийн програм хангамжийг боловсруулах;
- Осолд өртсөн, тэтгэвэр, тэтгэмж, зардал, төлбөр авсан, сэргээн засах тусламж, үйлчилгээнд хамрагдсан даатгуулагчийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны OHSAS 18001 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ажил олгогчийн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээллийг багтаасан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, Үндэсний дата төвд серверийг байршуулах;
- Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, сайжруулах, хяналт тавих ашиглах асуудлыг бодлого, зохицуулалтаар хийх;

ЗОРИЛТ VI: ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛГООР ХАМТАРСАН АЖЛЫН ХЭСГИЙГ ТАЛУУДЫН ТӨЛӨӨЛӨЛ ОРОЛЦУУЛАН БАЙГУУЛЖ, АЖИЛЛУУЛАХ;

- Төрийн болон төрийн бус байгууллага, судлаач, олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг байгуулах;
- Жил бүр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллах;
- Зохион байгуулсан ажил, үр дүнг талуудад тухай бүр мэдээлж, олон нийтэд сурталчилж ажиллах;